



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/14/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Цахим хаяг: Oyuntulkhur.u@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	
2.8.3 Авлага.....	6
2.8.4 Урьдчилгаа	
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	
2.8.6 Бараа материал	7
2.8.7 Үндсэн хөрөнгө	8
2.8.8 Өр төлбөр	8
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	12
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	26
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: domogovi@audit.gov.mn

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЭНХБАЯР ТАНАА

2020.03.25 № 1-6/348
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагч 6 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөрчилгүй, 1 хязгаарлалттай, 2 байгууллага түүврийн аудитад хамрагдсан. 3 сан түүвэр аудитад хамрагдсан байна.

- Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газар нэмэлт санхүүжилтийн дансанд 55.0 сая төгрөгийн хандив авсан, 15.1 сая төгрөгийн түлш шатахууныг бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд худалдан авалт хийсэн, 0.2 сая төгрөгийн цалин илүү олгосон нийт 70.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байх тул хязгаарлалттай дүгнэлт авсан.
- ОНХСангаар хийгдсэн Соёлын танхимын засварын ажилд батлагдсан төсвөөс 5.5 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн.

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 20.5 сая төгрөгөөр тогтоосон. Төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн материаллаг зөрчил нь 76.0 сая төгрөг букуу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан байна.

Үүрэг, хариуцлага

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл сумын Засаг дарга Н.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 20-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5/70 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2,050.4 сая төгрөгийн 1 хувь буюу 20.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 сан, ОНӨО-ийн нийт, 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4

байгууллага аудитын санал дүгнэлт, бусад 5 байгууллага, сан түүвэр аудитад хамрагдсан байна.

Аудитын санал дүгнэлтээр цэцэрлэг, ЭМТөв, Ерөнхий боловсролын сургууль “Зөрчилгүй”, ЗДТГазар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна

Хөвсгөл сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 162.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 67.2 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 0.3 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15.1 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 80.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүллээ. Нийт зөрчилд 19.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлээр үлдэх өртөггүй болсон зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг байдалд нөлөөлөхөөргүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 67.2 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- ОНХСангийн тайланд 21.6 сая төгрөгийн дуусаагүй барилгыг шууд зардалд бүртгэснийг залруулан бүртгэсэн.
- ИТХ-ын 38.8 сая төгрөгийн цалингийн бүртгэл хөтлөлтийн алдааг залруулан бүртгэсэн.
- ЗДТГ-ын өмнө оны нэмэлт дансны төвлөрүүлсэн авлагын барагдуулалтыг орлогоор бүртгэсэн залруулсан
- СХСангийн зээлийн хугацаа хэтэрсэн алдангийн орлогыг тооцоолж орлогоор бүртгээгүйг залруулсан

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 64.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 79.4 сая төгрөг болж 15.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	64.1	79.4	15.3	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	64.1	79.4	15.3	100.0

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд СХСангийн 65.3 сая төгрөг, ОНХСангийн 2.6 сая төгрөг, нөхөн сэргээлтийн сангийн 3.7 сая төгрөг, ЗДТГ-ын ахмадын сангийн 3.5 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн авлага 2.8 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 171.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 197.6 сая төгрөг болж, 78.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	0.2	0

Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага	0	55.0	55.0
Зээлийн хүүгийн авлага			0
Байгууллагаас авах авлага	7.6	3.3	-4.3
Зээлийн авлага	163.3	139.2	-24.1
Дүн	171.1	197.6	26.6

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Авлагын үлдэгдэлд: 2019 онд Сум хөгжүүлэх санд 2013-2018 онд олгосон 122.5 сая төгрөг, 2019 онд олгосон 16.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна. Зээлийн хугацаа хэтэрсэн 79.8 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн. ОНХСангийн авлага 55.0 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын сургууль- Хувь хүн албан байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй
- Соёлын төв- Жилийн эцэст 0.05 сая төгрөгийн авлага үүсгэсэн.
- ЭМТөв- Жилийн эцэст 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн
- ЗДТГ- Авлага өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй.

2.8.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 160.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 200.2 сая төгрөг болж, 39.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БАРАА МАТЕРИАЛ	160.76	200.22	39.46
Түүхий эд материал	11.64	22.39	10.75
Тусгай зориулалттай материал	8.31	6.17	-2.15
Эм боох материал	3.32	16.22	12.90
Хангамжийн материал	147.89	176.59	28.71
Бичиг хэргийн материал	7.51	11.47	3.96
Аж ахуйн материал	88.54	93.30	4.76
Сэлбэг хэрэгсэл	2.19	1.99	-0.20
Түлш, шатах тослох материал	19.03	28.86	9.83
Барилгын засварын материал	2.82	1.77	-1.05
Хүнсний материал	3.18	9.36	6.18
Бусад хангамжийн материал	24.63	29.85	5.22
Мал амьтад	1.24	1.24	0.00

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ- 15.1 сая төгрөгийн түлш шатахуунд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй.

2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3910.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4107.8 сая төгрөг болж, 197.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,910.77	4,107.85	197.08
Биет хөрөнгө	3,778.04	3,975.22	197.18
Барилга, байгууламж, орон сууц	2,993.24	3,092.89	99.65
Авто-тээврийн хэрэгсэл	59.52	99.85	40.33
Машин тоног төхөөрөмж(компьютер)	134.82	126.19	-8.63
Тавилга, аж ахуйн эд хогшил	97.40	89.16	-8.24
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3.19	3.19	0.00
Бусад үндсэн хөрөнгө	468.01	518.71	50.70
Дуусаагүй барилга, байгууламж		21.60	21.60
Ном	21.86	23.63	1.77
Биет бус хөрөнгө	132.73	132.63	-0.10
Програм хангамж	0.56	0.45	-0.10
Бусад биет бус хөрөнгө	132.18	132.18	0.00

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 32.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 8.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 327.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 9.9 сая, акталсан 75.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 21.6 / санхүүжилтийг нь олгосон барилга хүлээлгэж өгөөгүй дусаагүй байгаа / сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ЕБС, Соёлын төвд элэгдэж дууссан үндсэн хөрөнгийн үнэ болон ашигласан жилийг шинэчлээгүй байна

2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 19.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 60.0 сая төгрөг болж, 40.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Өглөг	19.8	60.0	40.6	100.0
Байгууллагад төлөх өглөг	19.8	60.0	40.6	100.0

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны 91.2 хувийг ОНХСангийн 55.0 сая төгрөгийн гүйцэтгэгч байгууллагад өгөх өглөг эзэлж байна.

2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4290.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4525.1 сая төгрөг болж, 234.4 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын хувь оролцоо	4,290.68	4,525.14	234.45	100
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,086.05	1,853.77	-232.28	40.97
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	224.16	224.16	4.95
Хуримтлагдсан үр дүн	544.15	787.23	243.08	17.40
Өмнөх үеийн үр дүн	1,382.50	561.14	-821.36	12.40
Тайлант үеийн үр дүн	-838.35	226.09	1,064.44	5.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,660.48	1,659.98	-0.51	36.68

Эх сурвалж: Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөвсгөл сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 08/07 дугаар тогтоолд зааснаар ОНХО-д тайлант онд 40.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 55.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлогын албан татвар	3.2	3.1	0.1	96,9%
Хадгаламжийн хүүгийн орлого	13.5	15.2	1.7	112,6%
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	15.1	24.9	9.7	164,9%
Бууны албан татвар	1.8	1.9	0.06	105,5%
Улсын тэмдэгтийн хураамж	0.9	1.0	0.1	133,3%
Хог хаягдлын төлбөр	4.0	6.8	2.8	170%
Түгээмэл тархацтай ашигт малтмал	1.1	2.1	1.0	190,9%
Хүү торгуулийн орлого	0.02	0.02	0	100%
Татварын бус орлого		0.1	0.1	100%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.5	0.6	0.1	120%
Нийт дүн	40.2	55.4	15.2	137,8%

- Үйл ажиллагааны орлогын албан татварын орлого 0.1 сая төгрөгөөр тасарсан нь бизнес эрхлэгч иргэдийн орлогоос шалтгаалсан байна.
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 9.7 сая төгрөгөөр давсан нь арьс шир ноосны урамшуулал орж ирснээс шалтгаалжээ.
- Бууны албан татварт 2 иргэний өмнө оны бууны татварын дутуу 0.06 сая төгрөг орсон.
- Хог хаягдлын хураамж 2.8 сая төгрөгөөр давсан нь Айл баян уурхайн бүтээн байгуулалтын ажил явагдаж хог хаягдал их гарч өндөр төлбөр төлсөн.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал 1.0 сая төгрөгөөр давсан нь Айл баян уурхай барилга барьж түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласанд төлбөр ногдуулсантай холбоотой.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 1553.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1336.8 сая төгрөгийг урсгал зардалд, 216.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын Тусгай шилжүүлэг 926.8 сая төгрөг, ОНХСан 169.0 сая төгрөг нийт 1095.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 504.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 0,5 сая төгрөг, нийт 1712.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1095.5 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 504.0 сая төгрөг 7.5 сая төгрөг Эрүүл мэндийн даатгалын сангаас, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас 0.5 сая төгрөгийн санхүүжилт орсон байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,631.6 сая төгрөг 80.7 сая төгрөг хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 17.4 сая төгрөгийг, тусгай шилжүүлгийн үлдэгдэл 5.3 сая төгрөгийг эргүүлэн төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 169.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 169.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 59.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 33,1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17.5 сая төгрөг, нийт 109.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 103.7 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 3.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.11. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 128 мэдээллийг хугацаанд нь, 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, сангуудын залруулагдаагүй материаллаг зөрчлийн дүнг нэгтгэн үзэхэд 76.0 сая төгрөг байх бөгөөд тогтоосон материаллаг байдлын түвшинээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгч байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Хөвсгөл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	399,728.26	477,294.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	64,103.87	79,417.20
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	64,103.87	79,417.20
31210	Төгрөг	64,103.87	79,417.20
31211	Төрийн сангийн харилцах	64,103.87	79,417.20
33	АВЛАГА	171,098.43	197,659.34
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	171.10	207.51
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	55,000.00
33500	Бусад авлага	7,627.44	3,284.86
33510	Байгууллагаас авах авлага	7,627.44	3,284.86
33600	Зээлийн авлага	163,299.90	139,166.97
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	163,299.90	139,166.97
33612	Хувь хүмүүст олгосон зээл	163,299.90	139,166.97
35	БАРАА МАТЕРИАЛ	160,762.85	200,218.08
35100	Түүхий эд материал	11,635.97	22,385.73
35110	Тусгай зориулалттай материал	8,314.74	6,169.16
35130	Эм боох материал	3,321.22	16,216.57
35400	Хангамжийн материал	147,886.89	176,592.35
35410	Бичиг хэргийн материал	7,505.63	11,467.01
35420	Аж ахуйн материал	88,536.81	93,301.68
35430	Сэлбэг хэрэгсэл	2,185.60	1,986.20
35440	Түлш, шатах тослох материал	19,029.02	28,862.09
35450	Барилгын засварын материал	2,821.20	1,767.00
35460	Хүнсний материал	3,177.59	9,356.04
35470	Бусад хангамжийн материал	24,631.04	29,852.34
35600	Мал амьтад	1,240.00	1,240.00
36	НӨӨЦИЙН БАРАА	3,763.10	0.00
36300	Тэжээлийн нөөц	3,763.10	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,910,772.11	4,107,847.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,910,772.11	4,107,847.14
39200	Биет хөрөнгө	3,778,040.06	3,975,217.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,009,572.59	3,164,642.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,336.83	-71,752.73

39203	Авто-тээврийн хэрэгсэл	182,237.79	230,618.79
39204	Хуримтлагдсан элэгдэл	-122,718.58	-130,765.89
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	453,933.77	457,610.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	-319,112.65	-331,422.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,366.37	194,221.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-96,966.73	-105,066.33
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,192.15	3,192.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	925,086.66	978,036.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	-457,072.83	-459,326.53
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	21,600.00
39217	Ном	21,858.35	23,628.13
39300	Биет бус хөрөнгө	132,732.04	132,629.58
39301	Програм хангамж	3,538.50	3,538.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,982.46	-3,084.92
39303	Бусад биет бус хөрөнгө	132,176.00	132,176.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,310,500.36	4,585,141.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,816.82	60,005.26
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,816.82	60,005.26
41300	Өглөг	19,816.82	60,005.26
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,884.05	39.82
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,610.80	177.55
41360	Бусад өглөг	6,321.98	59,787.89
41361	Байгууллагад төлөх өглөг	6,246.82	59,590.79
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	75.15	197.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,290,683.54	4,525,136.51
51	Засгийн газрын хувь оролцоо	4,290,683.54	4,525,136.51
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,086,045.85	2,077,925.85
51200	Хуримтлагдсан үр дүн	544,154.49	787,233.15
51210	Өмнөх үеийн үр дүн	1,382,500.99	561,143.63
51220	Тайлант үеийн үр дүн	-838,346.50	226,089.52
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,660,483.19	1,659,977.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,310,500.36	4,585,141.77

3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,791,409.79	2,050,362.15
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,613.53	55,234.95
110	Орлогын албан татвар	35,886.20	43,177.17
1100	Хувь хүний орлогын албан татвар	35,886.20	43,177.17
